



МОНГОЛ УЛС  
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 03 сарын 18 өдөр


Дугаар 01/2021

Номгон

Г Мал, амьтны отор нүүдэл, шилжилт  
хөдөлгөөнийг зохицуулах малчин өрхийг  
татаж авах түр журам батлах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3 "а", Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.4.3, Цагдаагийн албаны тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.1, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 43 дугаар тогтоолоор батлагдсан "Мал, амьтны шилжилт хөдөлгөөнийг зохицуулах, тээвэр, тууврын замд саатуулж, хорио цээрийн хяналтад авах" журмын 2.6, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2021 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн "Хаваржилтын болзошгүй хүндрэл, хүн, малын халдварт өвчин гарахаас урьдчилан сэргийлж, хорогдсон малын сэг зэмийг устгах, халдваргүйжүүлэх, отор, нүүдлийн мал, амьтны шилжилт хөдөлгөөнийг зохицуулах, хяналт тавих тухай" 01 тоот албан даалгаврыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. "Мал, амьтны отор нүүдэл, шилжилт хөдөлгөөнийг зохицуулах малчин өрхийг татаж авах" түр журмыг хавсралтаар баталсугай.
2. Түр журмын хэрэгжилтийг холбогдох байгууллагатай хамтран зохион байгуулж, удирдлага, арга зүйгээр хангаж ажиллахыг Мал эмнэлгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-т даалгасугай.
3. Малчид, иргэд, хуулийн этгээдэд сурталчлах, орон нутгийн төвшинд хэрэгжилтийг зохион байгуулахыг сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.
4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс /Т.Хишигбаатар/-т даалагсугай.

ДАРГА  Д.МӨНХСАЙХАН

1210461



МОНГОЛ УЛС  
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 03 сарын 18 өдөр


Дугаар 01124

Номгон

Г Мал, амьтны отор нүүдэл, шилжилт  
хөдөлгөөнийг зохицуулах малчин өрхийг  
татаж авах түр журам батлах тухай


Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3 "а", Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.4.3, Цагдаагийн албаны тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.1, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 43 дугаар тогтоолоор батлагдсан "Мал, амьтны шилжилт хөдөлгөөнийг зохицуулах, тээвэр, тууврын замд саатуулж, хорио цээрийн хяналтад авах" журмын 2.6, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2021 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн "Хаваржилтын болзошгүй хүндрэл, хүн, малын халдварт өвчин гарахаас урьдчилан сэргийлж, хорогдсон малын сэг зэмийг устгах, халдваргүйжүүлэх, отор, нүүдлийн мал, амьтны шилжилт хөдөлгөөнийг зохицуулах, хяналт тавих тухай" 01 тоот албан даалгаврыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. "Мал, амьтны отор нүүдэл, шилжилт хөдөлгөөнийг зохицуулах малчин өрхийг татаж авах" түр журмыг хавсралтаар баталсугай.
2. Түр журмын хэрэгжилтийг холбогдох байгууллагатай хамтран зохион байгуулж, удирдлага, арга зүйгээр хангаж ажиллахыг Мал эмнэлгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-т даалгасугай.
3. Малчид, иргэд, хуулийн этгээдэд сурталчлах, орон нутгийн төвшинд хэрэгжилтийг зохион байгуулахыг сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.
4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс /Т.Хишигбаатар/-т даалагсугай.

ДАРГА  Д.МӨНХСАЙХАН

1210461

Аймгийн Засаг Даргын 2021 оны 03 дугаар  
сарын 18-ны өдрийн А/184 дүгээр захирамжийн  
хэвсрэлт



**МАЛ, АМЬТНЫ ОТОР НҮҮДЭЛ, ШИЛЖИЛТ ХӨДӨЛГӨӨНИЙГ  
ЗОХИЦУУЛАХ МАЛЧИН ӨРХИЙГ ТАТАЖ АВАХ  
ТҮР ЖУРАМ**

**Нэг. Нийтлэг үндэслэл**

Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.4.3 Цагдаагийн албаны тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.1, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 43 дугаар тогтоолоор батлагдсан “Мал, амьтны шилжилт хөдөлгөөнийг зохицуулах, тээвэр, тууврын замд саатуулж, хорио цээрийн хяналтанд авах” журмын 2.6, Хүнс, хөдөө аж ахуйн хөнгөн үйлдвэрийн сайдын 2021 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн “Хаваржилтын болзошгүй хүндрэл, хүн, малын халдварт өвчин гарахаас урьдчилан сэргийлж, хорогдсон малын сэг зэмийг устгах, халдваргүйжүүлэх, отор, нүүдлийн мал, амьтны шилжилт хөдөлгөөнийг зохицуулах, хяналт тавих тухай” 01 тоот албан даалгаврыг хэрэгжүүлэх зорилгоор Баянхонгор аймгийн нутаг дэвсгэрт отор, нүүдлийн зориулалтаар тээвэрлэх, тууварлах болон отор нүүдлээр яваад буцаж өөрийн аймаг, сумын нутаг дэвсгэрт ирэх мал, амьтны шилжилт, хөдөлгөөнийг зохицуулахад энэ түр журмыг баримтална. Энэхүү түр журмыг 2021 оны 04 дүгээр сарын 01-ээс 2021 оны 08 дугаар сарын 20-ыг хүртэлх хугацаанд дагаж мөрдөнө.

**Хоёр. Аймгийн Мал эмнэлгийн газрын эрх, үүрэг**

2.1. Отроор нүүдэллэн ирэх малчин өрх, малын төрөл, тооны мэдээллийг урьдчилан авч, бусад аймгийн мал эмнэлгийн газартай хамтран өвөлжсөн болон дамжин өнгөрч байгаа аймаг, сумын мал, амьтны гоц халдварт өвчний байдал, цаг үеийн нөхцөл байдалтай уялдуулан нүүдэллэн ирэх замын маршрут гаргаж, мэргэжлийн байгууллагын хяналтан дор хүлээн авна.

2.2. Вакцинжуулалтад хамрагдаагүй бүсээс ирсэн малыг тухайн очсон нутаг дэвсгэрт 7 хоногийн хугацаанд хяналтад авна. Вакцинжуулалтад хамрагдсан бүсээс ирсэн бол 14 хоногийн хугацаанд хяналтад авна. Шаардлагатай тохиолдол хилийн зурвас газрын хяналтын цэгт түр саатуулж тодорхой хугацаанд хяналтад авч болно.

2.3. Гоц халдварт өвчний эрсдэлтэй бүс нутагт оторлож өвөлжсөн өрхийг 21-ээс доошгүй хоногийн хугацаанд өөрийн нутгийн бусад малтай холилдохгүйгээр

## 2.

нутаглуулах зөвлөмж, мэргэжлийн арга зүйгээр аймаг, сумын удирдлагыг хангах, шаардлагатай тохиолдолд урьдчилан сэргийлэх дархлаажуулалт зохион байгуулах бэлэн байдлыг хангах.

2.4. Малчдад зориулсан халдварт, гоц халдварт өвчний болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх талаар зөвлөмж гаргаж хүргүүлэх, мэдээллээр хангах.

2.5. Өөрийн аймаг сумдын Мал эмнэлгийн тасаг, Мал эмнэлгийн үржлийн нэгжийг мэргэжлийн удирдлага, арга зүйгээр хангаж ажиллах.

2.6. Бусад аймгийн нутаг дэвсгэрт отор, нүүдлээр малын шилжилт хөдөлгөөн хийсэн малчин, мал бүхий өрхийг өөрийн аймгийн нутаг дэвсгэрт шилжүүлэн авахдаа үндсэн харъяа сум орон нутгийн мэргэжлийн байгууллага /Мал эмнэлгийн тасаг, сумын Засаг дарга/, аймгийн Мал эмнэлгийн газрын саналыг үндэслэнэ.

2.7. Мал эмнэлгийн газар нь энэ түр журмын 2.6-д заасан саналыг гаргахдаа оторлож буй нутаг дэвсгэр дэх мал, амьтны гоц халдварт, халдварт болон шимэгчтэх өвчний тархвар зүйн судалгаа, урьдчилан сэргийлэх арга хэмжээний талаарх мэдээллийг харгалзан үзнэ.

2.8. Аймгийн мал эмнэлгийн газар нь бусад аймагт отор нүүдлээр явсан малчдыг нэвтрүүлэхдээ Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 7.11-д заасны дагуу шилжүүлэгч талаас “Мал эмнэлгийн цахим бүртгэлд баталгаажуулан мал эмнэлгийн гэрчилгээ гаргуулан” авна.

2.9. Энэ журмын 2.8-т заасан гэрээнд отроор явсан малчдын мал, амьтны төрөл, тоо, нэвтрэн ирэх чиглэлийг заасан “Мал эмнэлгийн гэрчилгээ”-г баримтална.

2.10. Хүлээн авах тал нь отор, нүүдлээр явсан малчдын мал сүргийг гоц халдварт, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, шимэгчтэх өвчнөөс эмчлэн сэргийлэх арга хэмжээнд бүрэн хамруулж хүлээн авна.

2.11. Халдварт өвчингүй, тайван болон тусгаарласан бүс нутаг руу мал, амьтны шилжилт хөдөлгөөн хийхдээ тухайн бүсэд мөрдөхөөр мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаас баталсан зааврыг дагаж мөрдөнө.

2.12. Хяналтын цэгийн болон мал эмнэлгийн хяналтын улсын байцаагч нь Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 7.6-д зааснаас гадна дараах

### 3.

тохиолдолд мал, амьтныг оторлон буцаж ирэхэд нь тээвэрлэх, тууварлах замд саатуулж, хорио цээрийн хяналтад авна.

#### Гурав. Цагдаагийн газрын эрх үүрэг

3.1. Мал, амьтны шилжилт хөдөлгөөн, Мал эмнэлгийн гэрчилгээнд хяналт тавьж мэргэжлийн байгууллагатай хамтран ажиллана. Мөн Цагдаагийн албаны тухай хуулийн 45 дугаар зүйлийг хэрэгжүүлнэ.

3.2. Отроор нүүдэллэн ирэх малчин өрх, малын төрөл, тооны мэдээллийг урьдчилан авч, цагдаагийн газарт мэдээлэл өгч хамтран ажиллах.

3.3. Вакцинжуулалатад хамрагдаагүй бүсээс ирсэн малыг тухайн очсон нутаг дэвсгэрт 7 хоногийн хугацаанд хяналтад авахаас өмнө тухайн орон нутгийн цагдаагийн газарт мэдээлэл өгч урьдчилан мэдэгдэж хамтран ажиллах.

3.4. Хүлээн авагч тал нь отор, нүүдлээр шилжилт хөдөлгөөн хийсэн малчдад хяналт тавих, хүлээн авах ажлын хэсэгт Сумын хэсгийн төлөөлөгч, хэсгийн цагдаа нарыг оруулах.

3.5. Улсын чанартай авто зам дамжин өнгөрдөг аймаг сумын нутаг дэвсгэрт мал, амьтны шилжилт хөдөлгөөн хийх, тээвэрлэх үед түр саатах, түр амраах цэгийг мал эмнэлгийн газар, тасгийн улсын байцаагчийн саналыг үндэслэн тухайн шатны Засаг дарга тогтоож, нутаг дэвсгэр хариуцсан хэсгийн төлөөлөгч, хэсгийн цагдаад мэдээлэл өгч хамтран ажиллах.

#### Дөрөв. Сумын Засаг дарга, Мал эмнэлгийн тасаг,

#### Мал эмнэлгийн аж ахуй нэгжийн эрх, үүрэг

4.1. Хүлээн авах тал нь отор, нүүдлээр явсан малчдын мал сүргийг халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, шимэгчтэх өвчнөөс урьдчилан эмчлэн сэргийлэх арга хэмжээнд бүрэн хамруулж хүлээн авна.

4.2. Хүлээн авагч тал нь отор, нүүдлээр шилжилт хөдөлгөөн хийсэн малчдад хяналт тавих, хүлээн авах ажлын хэсгийг байгуулна.

- Ажлын хэсгийн ахлагчаар сумын Засаг дарга.

- Гишүүдэд: Мал эмнэлгийн тасаг

- Хөдөө аж ахуйн тасаг

- Багын Засаг дарга нар

- Сумын Эрүүл мэндийн төв

- Сумын Засаг даргын тамгын газрын нөөц хүн хүчийг дайчлах.

4.3. Хамтарсан ажлын хэсэг нь отор, нүүдэл хийх явцад болон гэрээгээр тогтоосон нутаг дэвсгэрт зүй бусаар хорогдсон мал, амьтны хүүр, сэг зэмийг

#### 4.

цуглуулж устгах, бэлчээр, уст цэг, үерийн жалга, усны эх булгийг цэвэрлэх, явсан малчдын малыг эрүүл мэндийн үзлэгт хамруулах, хашаа, хороо, авто тээвэр, тоног хэрэгслийг халдваргүйжүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

4.4. Отор нүүдэл хийж очсон болон Байгалийн аюулт үзэгдлийн улмаас уруудсан мал, амьтныг буцаан тээвэрлэж, тууварлахаас өмнө тухайн мал, амьтан очсон нутаг дэвсгэрийн “Мал эмнэлгийн үйлчилгээний нэгж” нь өрхийн мал сүрэгт эмнэлзүйн шинж тэмдгийн үзлэг, тандалт хийж, халдварт өвчний холбогдолгүй болохыг баталгаажуулж тодорхойлолт /гэрчилгээ/ олгосон байх.

4.5. Мал, амьтны гоц халдварт өвчин түүний дархлаажуулалтад хамрагдсан байсан аймгийн нутагт оторлож байсан бол нүүдэл хийж очсон өрхийн мал сүрэгт үзлэг хийж Мал эмнэлгийн байгууллагаар баталгаажуулж тодорхойлолт, /гэрчилгээ/ олгосны дараа уг мал, амьтныг тээвэрлэх, эсхүл тууварлана.

4.6. Улсын чанартай авто зам дамжин өнгөрдөг аймаг, сумын нутаг дэвсгэрт мал, амьтны шилжилт хөдөлгөөн хийх, тээвэрлэх үед түр саатах, түр амраах цэгийг мал эмнэлгийн газар, тасгийн улсын байцаагчийн саналыг үндэслэн тухайн шатны Засаг дарга тогтоож, нийтэд мэдээлнэ.

4.7. Энэхүү журмыг малчид, иргэд, хуулийн этгээдэд сурталчлах, мэдээлэх, арга зүйгээр хангах үүргийг хүлээнэ.

4.8. Отрын мал, амьтны судалгааг сумдын Мал эмнэлгийн тасаг нарийвчлан гаргах бөгөөд аливаа гарах эрсдэл, асуудлыг сумын Засаг дарга, Мал эмнэлгийн тасаг бүрэн хариуцна.

4.9. Засгийн газрын 2019 оны 43 дугаар тогтоол, Мал эмнэлгийн ерөнхий газраас гаргасан Мал эмнэлгийн ажил, үйлчилгээ явуулах зөвлөмж зэргийг үндэслэн тухайн харьяалах нутаг дэвсгэрт отор нүүдэл хийх, дамжин өнгөрөх чиглэл, хугацаа, нутаг дэвсгэрийг тогтоож, хяналт тавьж ажиллах.

4.10. Мал хүлээн авахдаа сумын Мал эмнэлгийн тасаг, Мал эмнэлгийн үржлийн нэгжийн эмч нь нүүж ирсэн өрхийг өөрийн суманд өвөлжсөн малчинтай нэг хотонд буулгахгүй, хяналтад авах, үзлэг тандалт хийх арга хэмжээг зохион байгуулах.

4.11. Малчин, мал бүхий иргэдэд отроор нүүдэллэж ирсэн малтай малаа хяналтын хугацаанд нийлүүлэхгүй байх талаар зөвлөмж, мэдээлэл хүргэж ажиллах.

## 5.

4.12. Малчин өрх мал хүлээж авах цэгийг зааж тодорхой хугацаанд хорио цээр, хязгаарлалтын дэглэмийг зохион байгуулах, шаардлагатай тохиолдолд дээж материалыг авч Мал эмнэлгийн газрын лаборторт хүргүүлж шинжлүүлэх.

4.13. Мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээг технологит хугацаанд нь гүйцэтгэх, аливаа өвчний дуудлага, үйлчилгээг гүйцэтгэхдээ ковид-19-ийн халдвараас сэргийлэх халдвар хамгааллын дэглэмийг чанд мөрдөн, өөрийн болон бусдын эрүүл мэндийг хамгаалж ажиллах.

Тав. Малчин, хуулийн этгээдийн эрх, үүрэг

5.1. Энэ журамд заасан арга хэмжээг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлыг малчин, малчин өрх, хуулийн этгээд хариуцна.

5.2. Малчин, мал бүхий иргэн оршин суугаа газраасаа өөр аймаг, хот, сумын нутаг дэвсгэрт мал, амьтныг тууварлах, тээвэрлэх бол “Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 7.4-т заасан” шаардлагыг урьдчилан хангасан байна.

5.3. Отроор явсан малчин өрх буцаж өөрийн нутагт ирэхээр болсон бол сум орон нутгийн удирдлага, мал эмнэлгийн тасагт 3-7 хоногийн өмнө заавал мэдэгдэж Мал эмнэлгийн газар, Цагдаагийн байгууллагын шаардлагын дагуу хамтран зөвшөөрсөн тохиолдолд ирнэ.

5.4. Отроор явсан малчин өрх тогтоосон замын чиглэлийн дагуу мал, амьтныг тээвэрлэж, тууварлан, холбогдох байгууллагаас гаргасан журам, зааврыг мөрдөнө.

5.5. Мал, амьтныг тээвэрлэхдээ зориулалтын, эсхүл мал, амьтанд бэртэл гэмтэл учруулахгүй байхаар нэмж тоногдсон тээврийн хэрэгслийг ашиглах, тээвэрлэхийн өмнө механик цэвэрлэгээ, халдваргүйжүүлэлт хийлгэсэн байна.

5.6. Мал, амьтны шилжилт хөдөлгөөн, отор нүүдлийн үед хорогдсон мал, амьтны хүүр, сэг зэмийг цуглуулан хамтарсан ажлын хэсгийн багийхантай зөвшөөрсөн цэгт зааврын дагуу устгаж, мэргэжлийн байгууллагаар халдваргүйтгэлийг хийлгэж хамтран ажиллана.

5.7. Малын шилжилт хөдөлгөөний үед мал, амьтны өвчний сэжиг илэрсэн тохиолдолд тухайн сум орон нутгийн засаг захиргаа, мал эмнэлгийн байгууллагад яаралтай мэдээлнэ.

5.8. Улсын чанартай авто зам дамжин өнгөрдөг аймаг, сумын нутаг дэвсгэрээр мал, амьтны шилжилт хөдөлгөөн хийх бол тогтоосон цэгт түр саатах, түр амарна.

## 6.

5.9. Иргэн, хуулийн этгээд мал, амьтны шилжилт хөдөлгөөн хийхтэй холбоотой санал, гомдлоо холбогдох эрх бүхий байгууллагад гаргана.

5.10. Отор нүүдэл хийхээс өмнө болон нүүдэл хийх явцад мал олноор өвчилж, хорогдсон тохиолдолд мал эмнэлгийн байгууллагад яаралтай мэдэгдэнэ.

5.11. Мал эмнэлгийн байгууллагаас гаргасан маршрутын дагуу нүүдэллэх, малаа тууварлах замдаа бусад айлын малтай нийлүүлэхгүй.

5.12. Отор нүүдэл хийж нутагтаа ирсний дараа өөрийн сумын малчинтай нэг хотонд буухгүй байх, мал эмнэлгийн байгууллагаас 7-с доошгүй хоногийн хугацаанд хяналтад авах, үзлэг тандалт хийх нөхцөлийг бүрдүүлэх, мал эмнэлгийн байгууллагаас тавьсан хууль ёсны шаардлагыг биелүүлнэ.

### Зургаа. Хориглолт

6.1. Дараах тохиолдолд нэвтрүүлэхийг хориглоно.

6.1.1. Олон улсын хорио цээрт өвчин шүлхий, цэцэг, бог малын мялзан өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинд хамрагдсан бол сэжигтэй гэж үзэн нэвтрүүлэхгүй байх,

6.1.2. Мал эмнэлгийн гэрчилгээний хүчинтэй хугацаа дууссан бол,

6.1.3. Мал эмнэлгийн гэрчилгээнд бичигдсэн тээврийн хэрэгсэл солигдсон, өөрчлөлт хийсэн тэмдэглэл байхгүй бол,

6.1.4. Мал эмнэлгийн гэрчилгээнд бичигдсэн мал, амьтны төрөл, тоо, зүс, ялган тэмдэглэгээ нь цахим бүртгэлийн сангийн мэдээллээс зөрүүтэй бол,

6.1.5. Гэрчилгээний хүчинтэй хугацаанд тухайн мал, амьтны гарал үүсэл бүхий нутаг дэвсгэрт нь халдварт өвчин шинээр оношлогдсон бол,

6.1.6. Мал эмнэлгийн гэрчилгээнд бичигдсэн аймаг, сум дамжин өнгөрөх замын чиглэлийг зөрчсөн, дамжин өнгөрөх мал эмнэлгийн хяналтын цэгийн бүртгэл, тэмдэглэгээ хийгдээгүй, хяналтад ороогүй бол;

6.1.7. Мал, амьтны халдварт өвчний голомт илэрсэн нутаг дэвсгэрээр тухайн тээврийн хэрэгсэл дамжин өнгөрсөн талаар Мал эмнэлгийн байгууллагаас мэдээлэл ирүүлсэн бол нэвтрүүлэхийг тус тус хориглоно.

6.2. Отор, нүүдлээс бусад тохиолдолд аймгийн нутаг дэвсгэрт хивэгч мал, амьтан нэвтрүүлэхийг хориглоно.

### Долоо. Хариуцлага

7.1. Отор нүүдэлтэй холбоотой шилжилт хөдөлгөөнийг энэхүү журмаар зохицуулна. Хэрэв бусад хууль журамтай зөрчилдвөл Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийг баримтална.



7.

7.2. Журмын хэрэгжилтийг талууд бүрэн хангаж ажиллах бөгөөд журмыг зөрчсөн албан тушаалтан, хуулийн этгээдэд Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 36 дугаар зүйлд заасны дагуу хариуцлага тооцно.

\_\_\_\_\_оо\_\_\_\_\_